

**Солонгосын Байгаль орчны Яамны харъяа Биологийн Нөөцийн Хүрээлэн (СБНХ), МУИС
Хоорондын хамтын ажиллагаа**

Одоогийн ШУС-ийн Биологийн тэнхим, хуучнаар Биологи, биотехнологийн сургууль нь БНСУ-ын Биологийн Нөөцийн Хүрээлэнтэй 2011 онд Харилцан Ойлголцлын Санамж Бичигт гарын үсэг зурсанаас эхлэн нягт хамтын ажиллагааг өрнүүлэн ажиллаж байна.

Хамтын ажиллагааны хүрээнд хоёр талууд хамтарсан судалгааг явуулж улмаар туршлага судлах, харилцан мэдээлэл солилцох, залуу судлаачдыг дэмжих, харилцан ажилтан солилцох, хамтарсан хурал зохион байгуулах, МУИС-ийн дэргэд хамтарсан судалгааны төв болох урт хугацааны судалгааны хээрийн лаборатори, халуун усны газар байгуулах зэрэг талууд дээр хамтран ажиллаж байна.

Улмаар 2012 оны 6 сард Улаанбаатар хотноо Биологийн Оолон Янз Байдлын хамтарсан судалгаа хэрэгжүүлэх зорилгоор Зөвшилцлийн гэрээг байгуулж МУИС-ийн дэргэд Хамтарсан судалгааны төв байгуулах, хамтарсан судалгааны санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэн 2013-2016 онуудад дараах төслийг хэрэгжүүлэв.

Төслийн нэр: “Biodiversity Research Program and Establishment of Mongolia-Korea Biodiversity Research Cooperation Center” at the National University of Mongolia, Mongolia

“МУИС-ын дэргэд Монгол-Солонгосын Хамтарсан Биологийн Олон Янз Байдлын Судалгааны Төв байгуулах”

Хэрэгжүүлэгч талууд: МУИС-ийн Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим, Биологийн тэнхим

Төсөл хэрэгжих хугацаа: 3 жил (2013-2016)

Төслийн нийт санхүүжилт: 18,000 ам доллар, жил бүр

2013-2015 оны нийт төсөв, санхүүжилт: 102,694,422 төгрөг

Төслийн үндсэн зорилго:

(1) МУИС-ийн дэргэд Монгол-Солонгосын Хамтарсан Биологийн Олон Янз Байдлын Судалгааны Төв байгуулах,

(2) Хамтарсан Биологийн Олон Янз Байдлыг судлах хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хээрийн судалгааг явуулж судалгааны үр дүнд цуглуулсан дээж материалыг байгууллага тус бүрт хадгалан цаашдын нарийвчилсан судалгааг хэрэгжүүлж биологийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаар зөвлөмж боловсруулах, хамтарсан бүтээл туурвих,

(3) Ойн Сургалт, Судалгааны Төвийг түшиглэн Биологийн Олон янз Байдлын судалгааны урт хугацааны судалгааны талбай байгуулах, хээрийн судалгааны төв байгуулах

Энэхүү төслийн хэрэгжих хугацаанд БНСУ-ын Кёнгукийн Их Сургуульд МУИС-ийн төгсөгч Лхагвадоржийн Хүрэлцэцэг (2013~одоог хүртэл) докторантурт, Идэрзоригийн Бадамнямбуу (2013-2016) магистрантурт суралцан төгсөв.

Төслийн хугацаанд тус хүрээлэнд зохион байгуулагдсан Биологийн Олон Янз Байдлын хамгаалал, бүртгэл, дата боловсруулалт, бар-кодинг гэх мэт өндөр түвшний мэргэжлийн сургалтанд Монголын талын хамтрагч байгууллагууд (МУИС, ШУА, БОАЖЯ)-ын холбогдох багш, профессор, ажилтан, мэргэжилтэнүүдийг хамруулан оролцуулав.

№	Сургалтанд хамрагдсан хүний нэр	Байгууллага, сургалтын он
1	С.Гомбобаатар	МУИС, профессор, шувуу судлаач, 2011
2	Г.Сүхчулуун	ШУА, шувуу судлаач, 2011
3	Т.Мөнх-Эрдэнэ	ШУА, ургамал судлаач, 2016
4	О.Мөнхзул	ШУА, ургамал судлаач, 2016
5	Ш.Баасанмөнх	МУИС, ургамал судлаач, 2016

Төслийн багийн гишүүд:

No	Position	Major	Role	Remarks
1	Project leaders	Taxonomy, Ecology, Insect resources, Forest Science	Cooperation, investigation, and administration	Nyam-Osor Batkhoo (Mongolia) Kwon, Ohseok (Korea)
2	Principal researchers	Taxonomy, Ecology, Insect resources	Research on Korean endangered species and NE Asian endemic species (Lepidoptera), sample collection, publish articles	Badamdorj, Bayartogtokh (Mongolia), Cho, Youngho (Korea)
3	Principal researchers	Taxonomy, Ecology, Insect resources	Research on Korean endangered species and NE Asian endemic species (Hymenoptera, Diptera), sample collection, publish articles	Erdenechuleen Otgonjargal, (Mongolia), Lee, Jongwook / Han, Hoyeon (Korea)
4	Principal researchers	Taxonomy, Ecology, Plant resources, Fish	Research on the endangered species and NE Asian endemic species, sample collection, publish articles	Batlai Oyuntsetseg / Tseden Jamsran, (Mongolia) Korea: Park, Seonju / Choi, Seungho
5	Research students	Taxonomy, Ecology, Insect resources	Long-term research and monitoring of pollinator insects in Udleg station	Lkhagvadorj Khureltsetseg Idertzorig Badamnyambuu

Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн зарим ажлуудаас:

Хичээлийн 2-р байрны 428 тоот өрөөг тохижуулан Монгол-Солонгосын Хамтарсан Биологийн Олон Янз Байдлын Судалгааны Төв байгуулсанаас гадна судалгаанд шаардлагатай зарим багаж төхөөрөмжийг худалдан авч одоогийн Ойн генетик, экофизиологийн лабораторид байрлуулан ахисан түвшний сургалтанд ашиглаж байна.

Багажийн нэр, санхүүжүүлсэн байгууллага

Нэгжийн үнэ



Солонгосын Биологийн Нөөцийн Хүрээлэн, “Монгол-Солонгосын Биологийн Олон Янз Байдлын Судалгааны Төв”

24,275,760 төгрөг

Төхөөрөмжийн нэр, загвар:
УРГУУЛАНГИЙН ШҮҮГЭЭ: GC-300TL



Equipment name and model: Leaf Area Index –LAI-2200 **16,811,860 төгрөг**

Солонгосын Биологийн Нөөцийн Хүрээлэн, “Монгол-Солонгосын Биологийн Олон Янз Байдлын Судалгааны Төв”

Төхөөрөмжийн нэр, загвар: Навчны талбайн индекс тодорхойлогч-LAI-2200

Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Үдлэг дахь Ойн Сургалт, Судалгааны Төвийг түшиглэн Биологийн Олон янз Байдлын судалгааны урт хугацааны судалгааны талбай байгуулж, хээрийн судалгааны төв байгуулав. Хээрийн судалгааны төвийн барилгыг **16,381,200** төгрөгийн хөрөнгөөр

байгуулж оюутан, судлаачдын байрлах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор хээрийн судалгааны болон ахуйн хэрэгцээний бүхий хэрэгслээр хангаж байна.



Үдлэг дахь хээрийн судалгааны лаборатори (16.381.200 төг)



Үдлэг дахь Мониторинг судалгааны талбай



Монгол-Солонгосын Хамтарсан Биологийн Олон Янз Байдлын Судалгааны Төв

Төслийн үйл ажиллагааны хураангуй-Project activities (field trips, workshops and symposiums)

No	Timeline	Durations	Location	Participants	Accomplishment
1	Sept, 2011	4 days	Ulaanbaatar, Mongolia	President and 2 researcher	Agreed to sign MoU
2	Nov, 2011	5 days	Siem Reap, Cambodia	Batkhuu Nyam-Osor	Agreed to develop special project proposal for Mongolia
3	18-24 June, 2012	6 days	Ulaanbaatar, Huvsgul aimag	9 NUM professor, 8 Korean researcher	First Joint Symposium in Hatgal soum, Huvsgul province
4	6-8 Nov, 2013	4 days	Incheon, Korea	4 professors, NUM	Second Joint Symposium completed

5	Sept, 2013	3-5 years	Kyungbuk National University	2 graduate students	2 Mongolian students are studying in Kyungbuk National University for their degree
6	May, 2014	5 days	Ulaanbaatar, Mongolia	Project Leaders	Construction of "Mongolia-Korea Biodiversity Research Field Station" was completed 02 June 2014.
7	Jun, 2014	7~10 days	Mongolia	All members	NIBR team visited Mongolia and had opening ceremony of Field station. Khureltsesteg (PhD student) and Badmaanyambu (MSc) of KNU had their monitoring survey at Field station
8	Jul, 2014	3~5 days	Mongolia	All members	28 July~05 Aug, NIBR, KNU research team had field survey at Binder, Khentii province and Udleg Field station. 04 August had organized Joint International Symposium on Biodiversity research at the NUM.
9	Aug, 2014	7~10 days	Mongolia	All members	
10	Oct, 2014	3~4 days	Incheon, Korea	All members	16-18 Oct. 2014, International Symposium on Biodiversity in Northeast Asia were organized at the NIBR, Incheon, ROK
11	June, 2015	3 days	Ulaanbaatar, Mongolia	Project Leaders, NIBR officials	Discussion of 2015 planned activities and signed official MoU between MAS and NIBR
12	June, 2015	8 days	Ulaanbaatar and Udleg station, Mongolia	Project leaders and researchers	Discussion about field survey and implementation of TK project for 2015 with team of MAS
13	August, 2015	3 days	Ulaanbaatar, Mongolia	Project leaders and researchers	Checked all collected specimens and deposit materials of 2015 field work and made final list of specimens and agreed to deposit to NIBR
14	Oct, 2015	3~4 days	Korea, Incheon	Prof. Oyuntsetseg and Mr. Ser-Oddamba	Attended to the International Symposium and research assistance at the SNU and other Universities
15	Jan, 2016	3 days	Ulaanbaatar, Mongolia	Project leader	Discussion 2016 activities and agreed on project planning
16	Feb, 2016	1 day	Ulaanbaatar, Mongolia	Project leader and researcher	Book launching of at the National University of Mongolia with participants of over 20 person
17	May, 2016	14 days	Incheon, Korea	Mr. Munkh-Erdene	Mr. Munkh-Erdene from MAS, participated at 14 days training
18	June, 2016	4 days	Ulaanbaatar and Udleg station, Mongolia	Project leaders and researchers	Discussion about field survey and implementation of TK project for 2015 with team of MAS
19	August, 2016	3 days	Ulaanbaatar, Mongolia	Project leaders and researchers	Checked all collected specimens and deposit materials of 2016 field work and made final list of specimens and agreed to deposit to NIBR
20	Oct, 2015	3 days	Ulaanbaatar, Mongolia	Project leaders and researchers	Checked state of the forthcoming publication on Insects of Mongolia, discussion of TK project finalization 2016 activities
21	Oct, 2016	3 days	Korea	Prof. Batkhuu	Discussion of 2017 project proposal and MoA signing procedure





Дээж материалын тооллого, зүйлийн тодорхойлолт хийж буй байдал



Хээрийн судалгааны явц



Зүүн Хойд Азийн Орнуудын Хамтарсан Биологийн Олон Янз Байдлын Симпозиумд оролцогчид, 2013,
Солонгосын Биологийн Нөөцийн Хүрээлэн
Delegates from Mongolia for the International Symposium on Biodiversity Conservation in Northeast Asia, NIBR,
Incheon, ROK, 2013



Монгол-Солонгосын хамтарсан Биологийн Олон Янз Байдлын Симпозиум, 2014 оны сарын 04-ны өдөр,
МУИС, Улаанбаатар, Монгол
International Symposium on the Biodiversity of Mongolia and Korea. 04 Aug. 2014. National University of

Mongolia, Ulaanbaatar.



Delagates from Mongolia for the International Symposium on Biodiversity Conservation in Northeast Asia, NIBR, Incheon, ROK, 2014

2016 оны зарим үйл ажиллагааны зураг-SOME PICTURES OF 2016 ACTIVITIES




Хамтарсан бүтээлийн нээлтийн үйл ажиллагаа
Book launching ceremony at National University of Mongolia



Монгол-Солонгосын хамтарсан Биологийн Олон янз байдлын судалгааны хээрийн лабораторийн сүүдрэвч байгуулж буй байдал
 Construction of veranda for Mongolia-Korea Biodiversity Research Field Station





Батсүмбэр сумын Үдлэг бга дахь ОССТ-д байгуулсан халуун усны газрын ерөнхий харагдах байдал
Outside and inside view of the Shower room facility in Mongolia-Korea Biodiversity Research Field Station
(12.600.000 төг)


2016 онд Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Үдлэг дахь Ойн Сургалт, Судалгааны Төвийг түшиглэн Биологийн Олон янз Байдлын судалгааны урт хугацааны хээрийн судалгааны лабораторийг түшиглэн хээрийн судалгааны явцад судлаачдын ажиллах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор ариун цэврийн өрөө, халуун усны газрыг 12,600,000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтанд оруулан оюутан, судлаачид өргөнөөр ашиглаж байна.



COMMON INSECTS of MONGOLIA



Төслийн хүрээнд хэвлүүлсэн хамтарсан бүтээл



Төслийн хүрээнд тэтгэлэгт сургалтанд хамрагдан Магистрийн зэрэг хамгаалсан И.Баданямбуугийн Магистрийн ажлын хуулбар

Ийнхүү 2013-2016 онуудад хэрэгжүүлсэн “МУИС-ын дэргэд Монгол-Солонгосын Хамтарсан Биологийн Олон Янз Байдлын Судалгааны Төв байгуулах” сэдэвт төсөл амжилттай хэрэгжин төслийн үйл ажиллагааг Солонгос улсын зохих байгууллагууд хянан хэлэлцсэний төгсгөлд МУИС

болон СБНХ-ийн хоорондын хамтын ажиллагааг үргэлжлүүлэх, улмаар шинэ шатанд гаргах нь зүйтэйг дүгнэсэн байна.

Улмаар МУИС-ийн талын зохицуулагч ХШУИС-ийн багш, профессор Ням-Осорын Батхүү, Солонгосын талын зохицуулагч СБНХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Др. Ли Жае Хо болон холбогдох албан тушаалтнуудын хамтарсан уулзалтаар ярилцан тохирсоны дагуу:

- МУИС болон СБНХ-ийн хоорондын Хамтран Ажиллах Тухай Санамж Бичиг (MoU)-ийг харилцан хэлэлцэж тохирсоны дараа гарын үсэг зурж албажуулах
- Хамтын ажиллагааны дараагийн шатанд 2016 оноос “Research Project for the Restoration of Degraded Grasslands in Mongolia and Mass Production of Useful Biological Resources in Mongolia-Монгол улсын зарим ашигт ургамлыг үржүүлэх, түүнийг доройтсон газрын нөхөн сэргээхэд ашиглах боломж” сэдэвт төслийг хэрэгжүүлэн эхэлж байна.

Үүнтэй холбоотойгоор МУИС-ийн Захиргааны Зөвлөлөөр Хамтын Ажиллагааны Гэрээг шинэчлэх саналыг хэлэлцэн зохих журмын дагуу шийдвэр гаргуулж өгөхийг хүсэж байна.

2017 оны ажлын айлчлалын зорилго, төлөвлөгөө:

Солонгосын Биологийн Нөөцийн Хүрээлэнгийн Ерөнхийлөгч Моон Сүк, Бэк (Woonsuk, Baek) холбогдох албаны хүмүүсийн хамт Монгол улсад ажлын айлчлал хийх бөгөөд МУИС-д зочилж Хамтын Ажиллагааны Гэрээг үзэглэхээр төлөвлөн ажиллаж байна.

Айлчлалын зорилго:

- Монгол улсад хамтран ажилладаг байгууллагууд болох МУИС, ШУА, Ерөнхий болон Сорилын Биологийн Хүрээлэн, БОЯЖЯ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах тухай харилцан санал солилцох
- МУИС-ийн зочилж МУИС-ийн Захирал Я.Төмөрбаатартай уулзан санал солилцож, Хамтын Ажиллагааны Гэрээнд гарын үсэг зурах ёслолд оролцох
- МУИС-д зохион байгуулагдах “Common Insect of Mongolia” “Traditional Knowledge of Biological Resources” сэдэвт хоёр Хамтын бүтээл, номны нээлтэнд оролцож зохиогчид, хамтран ажиллагч байгууллагуудад номын дээжийг гардуулан өгөх ёслолд оролцох болно.

Айлчлалын хуваарь:

2017 оны 6-р сарын 12-14-ны өдрүүдэд

2017 оны 6-р сарын 12-ны өдрийн 21:50-д УБ-д хүрэлцэн ирэх

2017 оны 6-р сарын 13-ны өдөр: МУИС-д айлчлах, Хамтын Ажиллагаан д гарын үсэг зурах, номын нээлтийн ёслолд оролцох (хөтөлбөрийг тусгайд нь хүргүүлэх болно)

2017 оны 6-р сарын 14-ны өдөр: хамтрагч байгууллагуудын уулзалт, Үдлэг дахь Хамтарсан судалгааны хээрийн лаборатори, хэрэгжиж буй төслийн явцтай танилцах

2017 оны 6-р сарын 14-ны өдрийн 23:50-д УБ-аас Сөүл буцах

Хамтын ажиллагааны талаар мэдээлэл бэлтгэсэн:

Монголын талын зохицуулагч,

ХШУИС, Хүрээлэн буй орчин, ой инженерчлэлийн тэнхимийн багш:

Доктор, дэд профессор Н.Батхүү